

## Гадаад харилцаа

Японы нисэхийн сургууль нь 1990 оноос олон гадаад оюутнуудыг элсүүлэн авч гадаад харилцаагаа өргөжүүлж ирсэн.

Одоогоор Японы нисэхийн ахлах сургууль Яаманашид зуун арван дөрвөн гадаад оюутан (Монгол, Тайланд, Хятад, Бразил, Солонгос) мөн Японы нисэхийн ахлах сургууль Ишикавад дөчин зургаан гадаад оюутан (Монгол, Тайланд, Хятад, Бразил, Орос, Тонга) –ууд суралцаж байна.

Иймэрхүү хэмжээгээр гадаад оюутнуудыг элсүүлэн авч байгаа ахлах сургууль ховор бөгөөд өдөр болгон гадаад харилцаатай байдаг гэж хэлж болно.

Зөвхөн гадаад харилцаа гэхээсээ гадна нэг ангид сурч, дотуур байрандаа нэг өрөөнд амьдарч, бүхийл зүйлээ хамтран хийсэний хувьд өөр улсуудын соёл иргэншилтэй танилцаж байна.

Гадаад оюутнууд Япон оюутнуудтай хамтран тус бүрийн секц дугуйландаа хичээж өндөр амжилт гаргаж байгаа.

Эдгээр зүйлүүдээр дамжуулан Япон оюутнуудтай дотносог найз нөхөд болцгоож Японы түүх, соёлыг биеээрээ мэдэрч чаддаг.

Өөрөөр хэлвэл Япон оюутнуудийг гадаад харилцааны мэдрэмжтэй болоход тус болж байна.

Суралцаж байх хугацаандаа болон сургуулиа төгссөнийхөө дараа Шинэ Зеланд, Англи, Хятад зэрэг улсуудруу суралцахаар явдаг Япон оюутнууд ч байдаг.

Энд манай сургуулийн гадаад харилцааны үйл явц болон гадаад оюутнуудын амжилтын талаар танилцуулж байна.